ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/84/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН УГТААЛЦАЙДАМ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273204 Цахим хаяг: maitsetsegt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ....3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ....5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА....11
4. АУДИТЫН ТАЙЛАН....15
4.1 Ерөнхий зүйл....15
4.2 Материаллаг байдал....15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт....15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал....15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....16
4.5.1 Завсрын аудитын талаар....16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал....16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ....17
5.3 Зөвлөмж....18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ....19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХАА	Хөдөө аж ахуй
ОНХС	Орон нутгийн хөгжлийн газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.25 № 01/136

танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН УГТААЛЦАЙДАМ
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА П.ОЮУНБИЛЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын тамгын газар нь төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэн, төрийн үйлчилгээг иргэдэд хуулийн хүрээнд шуурхай хариуцлагатай шударга хүргэх эрхэм зорилготой ба тайлант хугацаанд ISO стандартын дагуу гэр бүлийн зөвлөгөө өгөх өрөөг шинээр байгуулж, төрийн албан хаагчдын өрөө тасалгааг тохижуулсан ба Фитнес клуб нээж, халуун усны асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласнаар батлагдсан зардлын төсвөөс хэмнэгдсэн 153,980.7 мянган төгрөгийг дутуу санхүүжүүлж, тайлант оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 20,436.5 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	**ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН**	**30,871,356.40**	**56,709,316.40**
33	**АВЛАГА**	**3,927,440.00**	**7,261,700.00**
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	36,240.00	0
33500	**Бусад авлага**	**3,891,200.00**	**7,261,700.00**
33520	Хувь хүмүүсээс авах авлага	3,891,200.00	7,261,700.00
35	**БАРАА МАТЕРИАЛ**	**26,943,916.40**	**49,447,616.40**
35100	**Түүхий эд материал**	**22,721,806.40**	**42,400,876.40**
35110	Тусгай зориулалттай материал	22,721,806.40	42,400,876.40
35400	**Хангамжийн материал**	**4,222,110.00**	**2,046,740.00**
35410	Бичиг хэргийн материал	2,208,800.00	911,520.00
35420	Аж ахуйн материал	666,000.00	550,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,315,000.00	535,000.00
35440	Түлш, шатах тослох материал	32,310.00	50,220.00
35600	Мал амьтад	0	5,000,000.00
2	**ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН**	**951,589,731.31**	**1,128,357,510.35**
39	**ҮНДСЭН ХӨРӨНГӨ**	**951,589,731.31**	**1,128,357,510.35**
39200	**Биет хөрөнгө**	**937,161,731.31**	**1,113,929,510.35**
39201	Барилга, байгууламж, орон сууц	694,941,338.66	698,941,338.66
39202	Хуримтлагдсан элэгдэл	-205,855,323.98	-241,920,585.10
39203	Авто-тээврийн хэрэгсэл	158,639,521.00	175,838,611.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-138,087,749.85	-108,800,819.51
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	293,919,567.00	388,120,193.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-101,294,706.65	-124,962,019.45
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	73,312,250.00	73,312,250.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17,126,379.69	-27,736,355.11
39209	Зам, гүүрийн байгууламж	768,255,100.00	768,255,100.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-754,756,350.00	-758,255,100.00
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	10,000,000.00	10,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	166,642,064.00	285,278,404.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-69,436,599.18	-82,150,507.14
39216	Дуусаагүй барилга, байгууламж	58,009,000.00	58,009,000.00
39300	**Биет бус хөрөнгө**	**14,428,000.00**	**14,428,000.00**
39301	Програм хангамж	1,645,000.00	1,645,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-165,000.00	-165,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	12,948,000.00	12,948,000.00
3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II**	**982,461,087.71**	**1,185,066,826.75**
4	**НИЙТ ӨР ТӨЛБӨР**	**0**	**129,900.59**
41	**БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР**	**0**	**129,900.59**
41300	**Өглөг**	**0**	**129,900.59**
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0	129,900.59
5	**ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН**	**982,461,087.71**	**1,184,936,926.16**
51	**Засгийн газрын хувь оролцоо**	**982,461,087.71**	**1,184,936,926.16**
51100	Засгийн газрын оруулсан капитал	575,954,182.52	575,954,182.52
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	575,954,182.52	575,954,182.52
51200	**Хуримтлагдсан үр дүн**	**201,028,831.83**	**403,504,670.28**
51210	Өмнөх үеийн үр дүн	181,537,522.91	201,028,831.83
51220	Тайлант үеийн үр дүн	19,491,308.92	202,475,838.45
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	205,478,073.36	205,478,073.36
6	**ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V**	**982,461,087.71**	**1,185,066,826.75**

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)**	**519,887,945.00**	**873,723,670.00**
12	**ТАТВАРЫН БУС ОРЛОГО**	**114,764,503.00**	**307,519,916.00**
120	**Нийтлэг татварын бус орлого**	**114,764,503.00**	**307,519,916.00**
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	111,792,003.00	295,928,156.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	2,972,500.00	11,591,760.00
13	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	**405,123,442.00**	**566,203,754.00**
1311	**Нэмэлт санхүүжилтийн орлого**	**43,169,242.00**	**118,567,554.00**
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,169,242.00	118,567,554.00
1320	**Орон нутгийн төсвөөс санхүүжих**	**361,954,200.00**	**447,636,200.00**
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	361,954,200.00	447,636,200.00
II	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН**	**498,990,386.08**	**517,355,896.91**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**498,990,386.08**	**517,355,896.91**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**481,911,970.38**	**468,066,596.91**
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	**219,688,273.00**	**188,940,247.56**
210101	Үндсэн цалин	147,790,347.00	146,461,742.56
210102	Нэмэгдэл	38,328,616.00	36,828,675.00
210104	Урамшуулал	0	5,649,830.00
210105	Гэрээт ажлын хөлс	33,569,310.00	0
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	**28,708,962.30**	**26,935,336.03**
210201	Тэтгэврийн даатгал	20,833,773.45	21,258,298.03
210202	Тэтгэмжийн даатгал	2,057,904.81	1,286,641.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,790,910.08	917,729.10
210204	Ажилгүйдлийн даатгал	354,233.38	296,854.60
210205	Эрүүл мэндийн даатгал	3,672,140.58	3,175,813.18
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	**29,597,147.00**	**31,425,602.00**
210301	Гэрэл, цахилгаан	3,117,469.00	3,559,480.00
210302	Түлш, халаалт	26,479,678.00	27,866,122.00
2104	**Хангамж, бараа материалын зардал**	**29,306,129.00**	**34,797,941.00**
210401	Бичиг хэрэг	2,188,700.00	2,516,280.00
210402	Тээвэр, шатахуун	20,594,029.00	25,860,011.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,232,500.00	1,200,000.00
210408	Бараа материал акталсны зардал	5,290,900.00	5,221,650.00
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	**1,879,000.00**	**1,539,793.00**
210604	Урсгал засвар	1,879,000.00	1,539,793.00
2107	**Томилолт, зочны зардал**	**2,329,500.00**	**5,932,400.00**
210702	Дотоод албан томилолт	2,329,500.00	5,932,400.00
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,**	**1,253,497.00**	**16,220,769.00**
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	303,497.00	15,110,919.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	438,000.00	438,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	162,000.00	283,850.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	300,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	88,000.00
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	**169,149,462.08**	**162,274,508.32**
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	69,891,526.00	42,048,298.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	104,000.00	0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	99,153,936.08	120,226,210.32
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	**17,078,415.70**	**49,289,300.00**
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	**0**	**28,852,842.00**
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0	4,178,372.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0	990,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	23,684,470.00
2134	**Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох**	**17,078,415.70**	**20,436,458.00**
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,078,415.70	20,436,458.00
III	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)**	**20,897,558.92**	**356,367,773.09**
V	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН**	**1,406,250.00**	**153,891,934.64**
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0	153,891,934.64
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	1,406,250.00	0
VI	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)**	**19,491,308.92**	**202,475,838.45**

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)**	**405,123,442.00**	**566,203,754.00**
13	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	**405,123,442.00**	**566,203,754.00**
1311	**Нэмэлт санхүүжилтийн орлого**	**43,169,242.00**	**118,567,554.00**
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод	43,169,242.00	118,567,554.00
1320	**Орон нутгийн төсвөөс санхүүжих**	**361,954,200.00**	**447,636,200.00**
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	361,954,200.00	447,636,200.00
II	**НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	**381,123,442.00**	**486,203,754.00**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**381,123,442.00**	**486,203,754.00**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**364,045,026.30**	**432,724,126.00**
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	**219,688,273.00**	**179,999,905.00**
210101	Үндсэн цалин	147,790,347.00	137,521,400.00
210102	Нэмэгдэл	38,328,616.00	36,828,675.00
210104	Урамшуулал	0	5,649,830.00
210105	Гэрээт ажлын хөлс	33,569,310.00	0
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	**28,679,217.30**	**24,401,500.00**
210201	Тэтгэврийн даатгал	20,634,711.60	16,949,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,052,364.65	1,770,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,786,598.16	1,420,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	397,248.95	430,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,808,293.94	3,831,000.00
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	**29,597,147.00**	**30,661,372.00**
210301	Гэрэл, цахилгаан	3,117,469.00	2,795,250.00
210302	Түлш, халаалт	26,479,678.00	27,866,122.00
2104	**Хангамж, бараа материалын зардал**	**16,204,800.00**	**21,428,300.00**
210401	Бичиг хэрэг	2,520,000.00	1,276,000.00
210402	Тээвэр, шатахуун	10,452,300.00	16,252,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,232,500.00	1,200,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	2,700,000.00
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	**1,499,547.00**	**1,500,000.00**
210604	Урсгал засвар	1,499,547.00	1,500,000.00
2107	**Томилолт, зочны зардал**	**2,329,500.00**	**5,512,400.00**
210702	Дотоод албан томилолт	2,329,500.00	5,512,400.00
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	**1,513,796.00**	**30,321,807.00**
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	563,796.00	29,211,957.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	438,000.00	438,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	162,000.00	283,850.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	300,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	88,000.00
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	**64,532,746.00**	**138,898,842.00**
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	64,428,746.00	138,898,842.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	104,000.00	0
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	**17,078,415.70**	**53,479,628.00**
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	**0**	**33,043,170.00**
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0	8,368,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	24,674,470.00
2134	**Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,**	**17,078,415.70**	**20,436,458.00**
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,078,415.70	20,436,458.00
III	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)**	**24,000,000.00**	**80,000,000.00**
V	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)**	**24,000,000.00**	**80,000,000.00**
22	**ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ**	**24,000,000.00**	**80,000,000.00**
2200	**Дотоод эх үүсвэрээр**	**24,000,000.00**	**80,000,000.00**
222001	Тоног төхөөрөмж	2,350,000.00	0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	21,650,000.00	80,000,000.00
VI	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)**	**-24,000,000.00**	**-80,000,000.00**
VIII	**НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)**	**0**	**0**

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	**2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	**575,954,182.52**	**217,264,734.36**	**169,750,861.91**	**962,969,778.79**
2	**Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт**	**0**	**0**	**11,786,661.00**	**11,786,661.00**
3	**Дахин илэрхийлсэн үлдэгдэл**	**575,954,182.52**	**217,264,734.36**	**181,537,522.91**	**974,756,439.79**
4	**Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт**	**0**	**-11,786,661.00**	**0**	**-11,786,661.00**
9	**Тайлант үеийн үр дүн**	**0**	**0**	**19,491,308.92**	**19,491,308.92**
10	**2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	**575,954,182.52**	**205,478,073.36**	**201,028,831.83**	**982,461,087.71**
11	**2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл**	**575,954,182.52**	**205,478,073.36**	**201,028,831.83**	**982,461,087.71**
13	**Дахин илэрхийлсэн үлдэгдэл**	**575,954,182.52**	**205,478,073.36**	**201,028,831.83**	**982,461,087.71**
19	Тайлант үеийн үр дүн	0	0	202,475,838.45	202,475,838.45
20	**2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл**	**575,954,182.52**	**205,478,073.36**	**403,504,670.28**	**1,184,936,926.16**

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү
II	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	**601,616,900.00**	**427,199,742.00**	**174,417,158.00**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**436,616,900.00**	**427,199,742.00**	**9,417,158.00**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**383,705,600.00**	**402,525,272.00**	**-18,819,672.00**
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	**215,048,600.00**	**179,999,905.00**	**35,048,695.00**
210101	Үндсэн цалин	165,148,000.00	137,521,400.00	27,626,600.00
210102	Нэмэгдэл	49,900,600.00	36,828,675.00	13,071,925.00
210104	Урамшуулал	0	5,649,830.00	-5,649,830.00
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх**	**29,031,500.00**	**24,401,500.00**	**4,630,000.00**
210201	Тэтгэврийн даатгал	20,429,600.00	16,949,600.00	3,480,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,150,400.00	1,770,400.00	380,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,720,400.00	1,420,400.00	300,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	430,100.00	430,100.00	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,301,000.00	3,831,000.00	470,000.00
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	**34,191,600.00**	**30,661,372.00**	**3,530,228.00**
210301	Гэрэл, цахилгаан	3,091,000.00	2,795,250.00	295,750.00
210302	Түлш, халаалт	31,000,600.00	27,866,122.00	3,134,478.00
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	0	100,000.00
2104	**Хангамж, бараа материалын зардал**	**21,428,300.00**	**21,428,300.00**	**0.00**
210401	Бичиг хэрэг	1,276,000.00	1,276,000.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	16,252,300.00	16,252,300.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,200,000.00	1,200,000.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,700,000.00	2,700,000.00	**0.00**
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	**1,500,000.00**	**1,500,000.00**	**0.00**
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00	**0.00**
2107	**Томилолт, зочны зардал**	**5,512,400.00**	**5,512,400.00**	**0.00**
210702	Дотоод албан томилолт	5,512,400.00	5,512,400.00	0.00
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний**	**32,270,200.00**	**30,321,807.00**	**1,948,393.00**
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	31,100,200.00	29,211,957.00	**1,888,243.00**
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	438,000.00	438,000.00	**0.00**
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	283,850.00	**16,150.00**
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	300,000.00	**0.00**
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	88,000.00	**44,000.00**
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	**44,723,000.00**	**108,699,988.00**	**-63,976,988.00**
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,723,000.00	108,699,988.00	**-63,976,988.00**
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	**52,911,300.00**	**24,674,470.00**	**28,236,830.00**
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	**52,911,300.00**	**24,674,470.00**	**28,236,830.00**
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн	52,911,300.00	24,674,470.00	**28,236,830.00**
22	**ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ**	**165,000,000.00**	**0**	**165,000,000.00**
221001	Их засвар	165,000,000.00	0	**165,000,000.00**
III	**ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР**	**601,616,900.00**	**447,636,200.00**	**153,980,700.00**
32	**ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ**	**385,047,200.00**	**447,636,200.00**	**-62,589,000.00**
320001	Орон нутгийн төсвөөс	385,047,200.00	447,636,200.00	**-62,589,000.00**
35	**ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС**	**216,569,700.00**	**0**	**216,569,700.00**
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	216,569,700.00	0	**216,569,700.00**

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
II	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	43,169,242.00	118,567,554.00
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	43,169,242.00	118,567,554.00
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	40,523,542.00	110,198,554.00
2104	**Хангамж, бараа материалын зардал**	700,000.00	
210402	Тээвэр, шатахуун	700,000.00	
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	563,796.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	563,796.00	
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	39,259,746.00	110,198,554.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,155,746.00	110,198,554.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	104,000.00	
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	2,645,700.00	8,368,700.00
2132	**Бусад урсгал шилжүүлэг**		8,368,700.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		8,368,700.00
2133	**Олгосон санхүүжилт, шилжүүлэг**	2,645,700.00	
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	2,645,700.00	
I	**ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР**	43,169,242.00	118,567,554.00
1311	**Нэмэлт санхүүжилтийн орлого**	43,169,242.00	118,567,554.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,169,242.00	118,567,554.00
III	**НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)**		
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын тамгын газар нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д “Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын ажлын алба нь тамгын газар байх бөгөөд доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 67.1.1-67.1.8-д заасан чиг үүргийг хэрэгжүүлдэг, Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын тамгын газар нь төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэн, төрийн үйлчилгээг иргэдэд хуулийн хүрээнд шуурхай хариуцлагатай шударга хүргэх эрхэм зорилготой байна.

Тайлант онд төрийн албан хаагчдын баримт бичиг, өрөө тасалгааг ISO стандартын дагуу тохижуулж, ЗДТГ-т гэр бүлийн зөвлөгөө өгөх өрөөг шинээр тохижуулсан ба Фитнес клуб нээж, халуун усны асуудлыг шийдвэрлэн ажилласан байна.

Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд нийт 510 мод, бут, сөөг тарьж ургуулсан ба Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийн хүрээнд нийт 15 эмэгтэйчүүдийг төсөлд хамруулсан байна.

Угтаалцайдам сумын Засаг даргын тамгын газар нь сумын Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 39 зорилт, 59 арга хэмжээг хэрэгжүүлэхээр байгуулан ажиллаж, 96,4 хувиар хэрэгжүүлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Угтаалцайдам сумын Засаг даргын тамгын газар нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамрагдаагүй, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

ЗДТГ-ын дотоод хяналтын зөвлөл нь 2022 онд 7 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөж, ажилчин албан хаагчдын цаг ашиглалт, автомашины ашиглалт, шилэн дансны хэрэгжилт, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд дотоод хяналтыг хийж, тайлагнасан байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын тамгын газрын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь ЗДТГ-ын даргын 2019 оны 6 дугаар сарын 24-ны өдрийн тушаалаар батлагдсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 202,605.7 мянган төгрөгөөр буюу 20,6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	3,927.4	7,261.7	3,334.3
Бараа материал	26,943.9	49,447.6	22,503.7
Үндсэн хөрөнгө	951,589.7	1,128,357.5	176,767.8
Нийт хөрөнгө	**982,461.1**	**1,185,066.8**	**202,605.7**
Өр төлбөр	0	129.9	129.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	982,461.1	1,184,936.9	202,475.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	**982,461.1**	**1,185,066.8**	**202,605.7**

Дээрх хүснэгтээс харахад авлага дансны үлдэгдэл 7,261.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,334.3 мянган төгрөг болж өссөн нь тайлант онд олгосон 1,400.0 мянган төгрөгийн урьдчилгаа суутгаагүй, 1,970.5 мянган төгрөгийн төлбөрийн актыг цалингийн зардлаас төлсөн, оны эхний авлага барагдуулаагүйгээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 49,447.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 22,503.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр соёлын төвийн дотор засварт акустик хавтан 20,000.0 мянган төгрөгөөр, худаг засварын материал 5,610.0 мянган төгрөгөөр худалдан авч нөөцөлсөн ба аймгийн ХХААГ-аас ирүүлсэн 5,000.0 мянган төгрөгийн хуц, ОНХС-аар хийгдсэн хаягжилтыг 6,591.7 мянган төгрөгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж, 5,221.6 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,128,357.5 мянган төгрөг болж, 176,767.8 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн хөрөнгө оруулалтаар 80,402,7 мянган төгрөг, сумын шилжих үлдэгдлээс 60,000.0 мянган төгрөг, нийт 140,402.7 мянган төгрөгөөр соёлын төвийн дээвэр засвар, орон нутгийн шилжих үлдэгдлээс 9,550.0 мянган төгрөгөөр соёлын төвд хөгжим, 5,000.0 мянган төгрөгөөр ЕБС-д тоног төхөөрөмж, Төв аймгийн Цагдаагийн газраас 4,500.0 мянган төгрөгөөр элентра машин баланс хооронд, Эм И Си Ти Эс ХХК-с шинэ хөдөө төслийн хүрээнд 162,181.8 мянган төгрөгийн трактор тоног төхөөрөмж, ОНХС-аар хийгдсэн гэрэлтүүлэг 56,995.2 мянган төгрөг, нийтийн эзэмшлийн хашаа 16,697.1 мянган төгрөг, хужрын хашаа 29,984.0 мянган төгрөгөөр, ангилдаг хогны сав 14,960.0 мянган төгрөг, худаг засвар 10,610.0 мянган төгрөгийн, нийт 450,885.8 мянган төгрөгийн хөрөнгийг орлогоор бүртгэж, 154,957.7 мянган төгрөгийн хөрөнгийг соёлын төвд шилжүүлж, 61,892.1 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устгасан нь нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 433,326.0 мянган төгрөг, нийт зарлагыг 433,326.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 48,238.8 мянган төгрөгөөр бууруулж, сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 09 тоот тогтоолоор урсгал зардлыг 385,087.2 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 165,000.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь төсөв захирагч төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй ба цалин, урсгал засвар, шатахуун, албан томилолтын зардлыг бууруулснаас шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 20,569.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, сумын ИТХ-ын 2022 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 05 тоот тогтоолоор ЗДТГ-ын урсгал зардлыг 405,616.9 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 31,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 196,000.0 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 601,616.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 447,636.2 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 427,199.7 мянган төгрөг буюу 71,1 хувьтай байгаа нь батлагдсан зардлын төсвөөс 153,980.7 мянган төгрөгийг дутуу санхүүжигдсэн байна. Энэ нь хөрөнгийн зардал /наадмын талбай/ тендер шалгаруулалт явагдаагүйгээс 85,000.0 мянган төгрөг, тэтгэвэрт гарах нэг удаагийн тэтгэмж олгогдоогүй 28,236.8 мянган төгрөг, орон тоо дутуу ажилласнаас хэмнэгдсэн цалингийн зардлын 35,048.7 мянган төгрөгийг дутуу санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106/80101-үндсэн үйл ажиллагаа	286,442.7	231,546.7	54,896.0	80,8%
2	70106/80103-гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээ	41,329.8	39,441.6	1,888.2	95.4%
3	70106/80106-баг хорооны үйл ажиллагаа	39,509.6	35,114.1	4,395.5	88.8%
4	70106/80802-ажил олгогчоос олгох тэтгэмж	52,911.3	24,674.5	28,236.8	46.6%
5	70106/80918-бусад	165,000.0	80,000.0	85,000.0	48%
6	70106/81102-орон нутгийн нөөц хөрөнгө	5,000.0	5,000.0	0	100%
7	70106/82801-улсын баяр наадам	5,000.0	5,000.0		100%
8	71411/81701-байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	3,723.0	3,723.0		100%
9	71411/82212-хур хог хаягдал, орчны бохирдол	2,700.0	2,700.0		100%
		601,616.9	427,199.9		

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд аймгийн Засаг даргын захирамжаар сонгуулиар чөлөөлөгдсөн тэтгэмжид 8,368.7 мянган төгрөг, соёлын төвийн дээвэр засварт 90,000.0 мянган төгрөг, малын халдварт өвчин урьдчилан сэргийлэх зардалд 1,020.6 мянган төгрөг, өвөлжилтийн бэлтгэл ажилд 3,220.0 мянган төгрөг, Засгийн газраас чөлөөлсөн усны санхүүжилт 9,604.2 мянган төгрөг Статистикийн хэлтсээс ХАА-н ээлжит тооллогын зардалд 3,372.3 мянган төгрөг, хөдөлмөр халамжаас ажил зуучлалын 36.0 мянган төгрөг, шагналын 300.0 мянган төгрөг, өмнөх оны буцаан төвлөрүүлсэн 2,645.7 мянган төгрөг, нийт 118,567.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн харилцах данснаас сонгуулиар чөлөөлөгдсөн 2 багийн даргын тэтгэмжид 8,368.7 мянган төгрөг, соёлын төвийн дээвэр засвар, зургийн үнэнд 82,501.2 мянган төгрөг, малын халдварт өвчин урьдчилан сэргийлэх зардлыг 3 мал эмнэлэгт шатахууны үнэнд 1,020.6 мянган төгрөг, өвөлжилт хүндэрсэнтэй холбоотойгоор шатахуунд 3,000.0 мянган төгрөг, худгийн насос, засвар, гэрлийн үнэ, ажиллагчдын урамшуулал 12,469.9 мянган төгрөг Статистикийн хэлтсээс ХАА-н ээлжит тооллогын зардалд 3,372.3 мянган төгрөг, хөдөлмөр халамжаас ажил зуучлалын 36.0 мянган төгрөг, шагналын 300.0 мянган төгрөг, Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа санд соёлын төвийн дээврийн засварын барьцаанд 7,498.8 мянган төгрөг, нийт 118,567.5 мянган төгрөгийг зарцуулжээ. ЗДТГ нь өвс тэжээлийн борлуулалтын орлогыг мал хамгаалах санд төвлөрүүлдэг байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106-орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2022.01.01-2022.12.31	Төрийн үйлчилгээг хуулийн иргэдэд хүртээмжтэй хүргэж, иргэдийн сэтгэл ханамжийг дээшлүүлнэ.	96,4%	595,193.9	420,776.9
2	71411-хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	2022.01.01-2022.12.31	Хур хог хаягдлын орчны бохирдлыг цэвэрлэж, цэвэр орчин бүрдүүлэх	100%	6,423.0	6,423.0
	ДҮН				165,000.0	427,199.9

Хэрэгжилт нь дутуу болон хангалтгүй байгаа төсөл хөтөлбөрийн шалтгаан нөхцөл байдлын талаар авч үзэхэд Орон нутгаас хийгдэх хөрөнгийн зардлын 85,000.0 мянган төгрөгийн тендер зарлагдаагүй учраас хэрэгжилт 48 хувьтай байна .

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Майцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 03/02 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны батлагдсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг үзүүлэлтээр Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын тамгын газрын төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийн 2022 оны нийт зарлага 405,616.9 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 6,084.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,563.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласнаар Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр батлагдсан зардлын төсвөөс 25,6 хувь буюу тендер шалгаруулалт явагдаагүйгээс 85,000.0 мянган төгрөг, тэтгэвэрт гарах нэг удаагийн тэтгэмж олгогдоогүй 28,236.8 мянган төгрөг, орон тоо дутуу ажилласнаас хэмнэгдсэн цалингийн зардлын 35,048.7 мянган төгрөг дутуу санхүүжигдэж хэмнэгдсэн ба тайлант хугацаанд орон нутгийн төсвөөс олгосон урсгал зардлын санхүүжилт хэмнэгдэж, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 20,436.5 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Угтаалцайдам сумын Засаг даргын тамгын газар нь шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих мэдээллийг хугацаандаа байршуулсан төлөвтэй боловч цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 115,364.8 мянган төгрөгийн 5 орлогын, 26,478.5 мянган төгрөгийн 2 зарлагын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын тамгын газрын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 төлбөрийн акт, 1 албан шаардлага, зөвлөмж нэг өгөгдсөнийг хэрэгжүүлэн, ЗДТГ-ын даргын 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 03/11 дугаартай албан бичгээр хэрэгжилтийг ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	2,760.5	3	2,760.5	100
Албан шаардлага	1	21,650.0	1	21,650.0	100
Зөвлөмж	1	1,982.1	1	1,982.1	100
Нийт дүн	**5**	**26,392.6**	**5**	**26,392.6**	**100**

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Угтаалцайдам сумын Засаг даргын тамгын газрын дараагийн аудитаар шатахууны тайлан гаргалт, жолоочийн тооцоо бодсон байдалд анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 237,303.6 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 237,303.6 мянган төгрөгийн алдааг залруулав.

1.Мөнгөн гүйлгээний тайланд хөрөнгийн зардлыг 74,957.7 мянган төгрөгөөр, цалингийн зардлыг 8,940.3 мянган төгрөгөөр, НДШ 2,533.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгагдсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д ”үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

2. Авто тээврийн хэрэгсэл дансанд 105,872.7 мянган төгрөгийн үнэ бүхий хадуур, үрлүүр, хаман боогчийг, тавилга эд хогшлын дансанд 14,960.0 мянган төгрөгийн хогийн савыг, тусгай зориулалтын материал дансанд 5,000.0 мянган төгрөгийн үнэтэй 20 толгой өсвөр хуц, 25,039.1 мянган төгрөгийн үнэтэй акустик хавтан болон барилгын материалыг буруу ангилан бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д ”үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “ангилал”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 7,161.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 4,270.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 2,891.5 мянган төгрөгийн албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

1. Тайлант онд олгосон цалингийн урьдчилгаа 1,400.0 мянган төгрөг, оны эхний цалингийн урьдчилгааны үлдэгдэл 900.0 мянган төгрөгийг суутган барагдуулаагүй ба өмнөх оны санхүүгийн аудитаар бичигдсэн төлбөрийн акт 1,970.0 мянган төгрөгийг цалингийн зардлаас төлсөн зөрчил илэрлээ.

Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.4-д “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 5.1.5-д “Хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн

аудитын “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.5-д “бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Авлага дансны үлдэгдэлд 2,891.5 мянган төгрөгийн эзэн тодорхойгүй авлага байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.7-д “авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй” бол гэж заасныг үндэслэн албан шаардлага бичив.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шатахуун тооцоо бодолттой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Суудлын автомашины жолоочийн замын хуудсанд захиалагчийн нэр зөвшөөрсөн дарга, нягтлан бодогчийн нэр бичээгүй, албажуулаагүй, автомашин хэрэглэх захиалгын хуудас бичсэн, захиалсан хүний болон захиалгыг баталсан даргын гарын үсэг байхгүй, захиалгыг хянаж шатахуун олгох зөвшөөрлийн тэмдэглэл, гүйцэтгэлийг хүлээн авсан ажилтны гарын үсэг зурж албажуулаагүй гүйцэтгэлийн тэмдэглэл байхгүй, шатахууны зөвшөөрөл олгохдоо маршрут хуудасгүйгээр Тамгын газрын дарга бичдэг байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасны болон санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж

Шатахуун олголт, тайлан гаргалт, тооцоо бодолтод тавих хяналтыг сайжруулж, сар бүр тооцоог нэгтгэн бодож хэвших

2. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих мэдээллийг хугацаандаа байршуулсан төлөвтэй боловч цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 115,364.8 мянган төгрөгийн 5 орлогын, 26,478.5 мянган төгрөгийн 2 зарлагын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" гэж заасантай бүрэн нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн мэдээлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Буруу зөрүүтэй	1	86,431.8			1	86,431.8	1	86,431.8				
Буруу ангилан бүртгэсэн	1	150,871.8			1	150,871.8	1	150,871.8				
Дүн	2	237,303.6			2	237,303.6	2	237,303.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Урьдчилгаа суутгаагүй	1	4,270.0	1	4,270.0								
Авлагыг хариуцагч эзэн тодорхойгүй	1	2,891.5			1	2,891.5						
Жолоочийн тооцоо шатахуун зарцуулалт	1						1					
Дүн	4	7,1 61.5	1	4,270.0	1	2,891.5	1					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5 орлогын, 2 зарлагын гүйлгээг мэдээлээгүй	1	141,843.3					1	141,843.3
Дүн	1	141,843.3					1	141,843.3
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	141,843.3					1	141,843.3